

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2023 оны ... дугаар сарын ... ны
өдрийн ... дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТЭРЧ БУЙ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ХҮЛЭЭЛЦЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын хилээр нэвтэрч буй худалдан авсан болон түрээсээр ашиглах хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх /цаашид "хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх" гэх/-тэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх үйл ажиллагаанд үнэн зөв, шуурхай, ил тод, хууль тогтоомжийг сахин мөрдөх зарчмыг баримтална.
- 1.3. Энэхүү журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлгөөн зохицуулалтын төв, суурь бүтэц эзэмшигч, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, өмчлөгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.
- 1.4. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх ажилтан, иргэн, хуулийн этгээд нь Олон улсын төмөр замын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, журам, стандарт, Монгол Улсын хил, гаалийн байгууллагын холбогдох эрх зүйн акт, хилийн төмөр замын өртөөний технологийн горим, энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.
- 1.5. Энэхүү журамд хэрэглэх нэр томъёо, тодорхойлолтыг Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, журам, үндэсний стандартад заасан утгаар ойлгож хэрэглэнэ.
- 1.6. Монгол Улсын хилийн төмөр замын өртөө нь хөдлөх бүрэлдэхүүнд техникийн болон хил, гаалийн үзлэг, шалгалт хийх нөхцөлөөр бүрэн хангагдсан байна.
- 1.7. Монгол Улсын хилээр нэвтэрсэн илчит тэргийг илгээхдээ тухайн суурь бүтэц эзэмшигч байгууллагын зүтгүүрийн инженер, техникийн ажилтан ТУ-25 актыг бүрдүүлснийг үндэслэн хөдөлгөөнд оролцуулна.
- 1.8. Онцгой байдлын үед шуурхай нэвтрүүлэх шаардлагатай /аврах, сэргээн босгох, гал унтраах галт тэрэг, бүтээн байгуулалттай холбоотой зайлшгүй шаардлагаар нойтон түрээсээр ашиглах зам, засварын машин механизм г.м/ хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд энэ журам хамаарахгүй. Харин хилийн төмөр замын өртөөний удирдлага хилээр орсон болон гарсан хөдлөх бүрэлдэхүүний талаарх холбогдох мэдээллийг Хөдөлгөөн зохицуулалтын төвд өгнө.

Хоёр. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд тавигдах техникийн шаардлага

2.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1. хөдлөх бүрэлдэхүүний баримт бичиг нь Олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын хууль, стандартад заасан шаардлагыг хангасан байх;

2.1.2. хөдлөх бүрэлдэхүүн нь техникийн байдлыг тодорхойлох техникийн баримт бичиг /гэрчилгээ/-тэй байх;

2.1.3. хөдлөх бүрэлдэхүүн нь шинэ эсхүл ашиглалтын хугацаа нь үйлдвэрлэгчээс тогтоосон хугацааны 1/3 /гуравны нэг/-ээс хэтрэхгүй байна. Уг хугацаанаас хэтрэхгүй ашигласан хөдлөх бүрэлдэхүүнийг оруулж ирэхдээ эрх бүхий байгууллагаар засвар, оношилгоо хийлгэсэн байх, мөн техникийн бүрэн бүтэн байдал, хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангаж байгааг нотолсон баримт бичгийг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага нь бүрдүүлсэн байна.

2.1.4. худалдан авч байгаа вагоны хатуу дугаартай цутгамал эд ангийн насжилт нь вагоны ашиглагдсан хугацаанаас ихгүй байна.

2.1.5. хөдлөх бүрэлдэхүүн оруулж ирж байгаа иргэн, хуулийн этгээд нь тухайн хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хариуцах ба шаардлагатай засвар, техникийн үйлчилгээнд хамруулж ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангасан байна.

2.2. Монгол Улсын хилээр шинээр оруулан ирж, төмөр замын тээвэрт ашиглах хөдлөх бүрэлдэхүүний техникийн нөхцөл, шаардлага, дугаарлалт, тэмдэг тэмдэглэгээ нь энэхүү журамд заасан баримт бичгийн шаардлагыг хангасан байна. Мөн тухайн улсын нутаг дэвсгэр дээр худалдан авах болон түрээслэх хөдлөх бүрэлдэхүүнд хийсэн техникийн үзлэг, акт дүгнэлтийг ирүүлсэн байна.

2.3. Олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын хууль, стандарт, энэхүү журамд заасан шаардлагыг хангаагүй хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын төмөр замын тээврийн хөдөлгөөнд оролцуулахгүй. Монгол Улсын хилээр нэвтрүүлж, төмөр замын тээвэрт ашиглах хөдлөх бүрэлдэхүүний анхны модель зураг хийцэд өөрчлөлт оруулахгүй бөгөөд түүний эд анги, тоног төхөөрөмж бүрэн бүтэн хэвийн ажиллагаатай байвал зохино. Хөдлөх бүрэлдэхүүн нь шат бариул, гар тоормосоор бүрэн тоноглогдсон байна.

2.4. Хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд Гаалийн тухай хуульд заасны дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.5. Монгол Улсын төмөр замын тээвэрт ашиглагдах хөдлөх бүрэлдэхүүний түрээсийн хугацаа нь дунд засварын хугацаанаас хэтрэхгүй байна.

2.6. Монгол Улсад өмнө нь ашиглагдаж байгаагүй хөдлөх бүрэлдэхүүнийг хилээр нэвтрүүлэхдээ Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон суурь бүтэц эзэмшигчид урьдчилан мэдэгдсэн байна.

Гурав. Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэл хөтлөх

3.1. Иргэн, хуулийн этгээд нь хөдлөх бүрэлдэхүүнтэй холбоотой дараах мэдээллийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж, зөвшөөрөл авсны дараа Монгол Улсын хилээр нэвтрүүлнэ. Үүнд:

3.1.1. хөдлөх бүрэлдэхүүн шинээр худалдан авах, түрээслэх иргэн, хуулийн этгээдийн дүгнэлт гаргуулах албан хүсэлт;

3.1.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар;

3.1.3. хөдлөх бүрэлдэхүүний төрөл, хийц, бүдүүвч, гэрэл зураг, үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн үзүүлэлт, ашиглах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон баримт бичиг;

3.1.4. хөдлөх бүрэлдэхүүнд засвар, оношилгоо үйлчилгээ хийгдсэн байдлыг тодорхойлсон баримт бичиг, техникийн байдлын талаарх дүгнэлт, гэрчилгээний хуулбар;

3.1.5. худалдан авах болон түрээслэхтэй холбоотой гэрээний хуулбар, түүний баталгаат орчуулга;

3.1.6. хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах, түрээслэх, ашиглах иргэн, хуулийн этгээд нь суурь бүтэц эзэмшигчээс тээвэрт оролцуулах тухай зөвшөөрөл;

3.1.7. хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах, түрээслэх, ашиглах иргэн хуулийн этгээд нь суурь бүтэц эзэмшигчтэй байгуулсан урсгал засвар үйлчилгээний гэрээ;

3.2. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичиг, холбогдох мэдээлэл, тээвэрлэгчийн саналыг үндэслэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж, хөдлөх бүрэлдэхүүний техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, журам, үндэсний стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргана.

3.3. Дүгнэлт нь хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын төмөр замын тээвэрт ашиглах, эс ашиглах үндэслэл болно.

3.4. Ажлын хэсгийн ажиллах зардлыг тухайн хүсэлт гаргагч хариуцна.

3.5. Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч болон түрээслэгч иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний талаарх шаардлагатай мэдээллийг төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний мэдээллийн нэгдсэн санд Хөдөлгөөн зохицуулалтын төвөөр дамжуулан бүртгүүлсэн байна.

3.6. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь дүгнэлт, шийдвэрийг үндэслэн худалдан авсан хөдлөх бүрэлдэхүүнд дугаар, өмчлөгчийн код, түрээсээр ашиглах хөдлөх бүрэлдэхүүнд түрээслэгчийн код шинээр олгож, мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, суурь бүтэц эзэмшигчийг мэдээллээр ханган ажиллана.

3.7. Үйлдвэрлэгчээс худалдан авсан хөдлөх бүрэлдэхүүнд худалдах, худалдан авах гэрээ болон Хөдөлгөөн зохицуулалтын төвтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр хөдлөх бүрэлдэхүүний дугаарыг урьдчилан олгож болно. Энэхүү журмын 3.2-т заасан дүгнэлтээр хөдлөх бүрэлдэхүүн тэнцээгүй тохиолдолд Хөдөлгөөн зохицуулалтын төв урьдчилан олгосон дугаарыг буцаан авна.

3.8. Хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах, түрээслэх, ашиглах иргэн, хуулийн этгээд нь төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, суурь бүтэц эзэмшигч болон техникийн үзлэг, оношилгоо, техникийн засвар үйлчилгээ хариуцан гүйцэтгэх байгууллагаас зөвлөгөө авч болно.

3.9. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь жил бүрийн эхэнд худалдан авах, түрээслэх хөдлөх бүрэлдэхүүний төрөл, тоог хөдлөх бүрэлдэхүүний эрэлт хэрэгцээ, суурь бүтцийн багтаамж, вагон урсгалын тооцоололд үндэслэн, холбогдох байгууллагуудаас санал авч, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх боломжит хөдлөх бүрэлдэхүүний тоог тодорхойлно. Шаардлагатай тохиолдолд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэсэгчлэн хязгаарлалт хийж болно.

3.10. Хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах, түрээслэх, ашиглах иргэн, хуулийн этгээд нь өөрийн салбар замтай байх эсхүл салбар зам эзэмшигч байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

3.11. Түрээсийн хөдлөх бүрэлдэхүүний гэрээний хугацаа дуусгавар болох, хөдлөх бүрэлдэхүүнийг давхар түрээслэх, өөрийн эзэмшлийн төмөр замд засварт орохоор буцах, шаардлагатай үед хөдлөх бүрэлдэхүүн хилээр гарах тохиолдолд Хөдөлгөөн зохицуулалтын төвд заавал мэдэгдэнэ.

Дөрөв. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэх

4.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэхдээ суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нь энэхүү журмын 1.4, 3.1-3.2-т заасан баримт бичгийн шаардлагыг ханган бүрдүүлж хөтөлнө.

4.2. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх ажиллагааг тухайн суурь бүтэц эзэмшигч, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч харилцан зөвшилцөн зохион байгуулж, Монгол Улсын хилийн боомт болон хилийн өртөөнд гүйцэтгэнэ.

Тав. Хяналт, хариуцлага

5.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлгөөн зохицуулалтын төв, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч тус тусын чиг үүргийн хүрээнд энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавина.

5.2. Суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч, тээвэрлэгч нь "Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам"-д заасны дагуу

ашиглагдаж байгаа болон нөөцөд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын тайлан, судалгааг хагас, бүтэн жилээр гарган, Хөдөлгөөн зохицуулалтын төвд ирүүлж, тус байгууллага нь тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулан, хяналт тавина.

5.3. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлгөөн зохицуулалтын төв, суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нь энэ журамд зааснаас өөр үйл ажиллагаа хэрэгжүүлэх, бусад баримт бичгийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.

5.4. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2023 оны ... дугаар сарын ... ны
өдрийн ... дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

**Хүйтэн байдалд зөөвөрлөхөд зориулсан зүтгүүр (кран), моторт-вагон
галт тэрэгний (секц) техникийн байдлыг шалгах
АКТ /Маягт ТУ-25/**

20__ оны __ сарын __ өдөр бид, дор гарын үсэг зурсан бүрэлдэхүүнээр

_____ (зүтгүүрийн (кран), мотортвагон, секц)
_____ серийн № _____ дугаартай зүтгүүрийн техникийн байдлыг шалгаж энэхүү актыг
тогтоов:

а) дэлний хэмжээ хамгийн бага _____
хос дугуй баруун талдаа _____ мм, зүүн талдаа _____ мм;

б) бандаж нь хамгийн их хурц ирмэгтэй _____ хос дугуй
_____ талдаа _____ мм;

в) хос дугуйн хөндлөн гүйлт _____;
(хэвийн хэмжээнд)

г) бүх хос дугуйн дэлэнд _____
(ямар нэгэн)

_____ (хурц ирмэг)
д) явах ангийн хөдөлгөөнт механизмуудыг тослох төхөөрөмжүүдийг шалгасан
_____;

_____ (гэмтэлгүй байдалтай байх)
Үрэлдэгч эд ангиудад тосолгооны хангамж _____;
(хэвийн)

е) тоормос, тэр тусмаа гар тоормос _____;
(гэмтэлгүй)

ж) хамгаалах төхөөрөмжүүд _____
(гэмтэлгүй)

з) Уурын тэрэгний засварын дүрэмд тусгагдсан гүйлтийн болон дэмжих тэргэнцрийн
хяналтын хэмжээсүүдийн байдал _____;

и) Дагалдан хүргэгчид зориулсан зуух болон ороор тоногдсон
_____;

(зүтгүүрийн (моторт вагон) үйлдвэрлэгчийн зургийн шаадлага эсвэл ПКБ, ЦТ.
шаардлагын дагуу, хос татлагын нэгдсэн кранд чөлөөтэй хүрэх боломжтой);

к) энэ серийн шинэ зүтгүүрийг тээвэрлэх тэр тусмаа хүйтэн байдалд аюулгүй
тээвэрлэх тухай зүтгүүрийн үйлдвэрийн техникийн нөхцлийн бүх шаардлагыг
_____;

_____ (бүрэн гүйцэтгэх)

л) краны сум ба түүний тулгуур

_____ (тээвэрлэлтийн байдалд бэхэлсэн)

1. _____
(зүтгүүр, моторт вагон, кран, секцийн нэр)

Техник ашиглалтын журам, зүтгүүр ба моторт вагон (кран) _____ замналын хурдтайгаар тээвэрлэх зааврын шаардлагад нийцүүлэн хүйтэн байдалд тээвэрлэхэд зориулан бэлтгэгдсэн.

2. Хүйтэн байдалд зүтгүүр (кран), моторт вагон (секц) тээвэрлэхэд дагалдан хүргэгчид энэхүү актын хувийг хүлээлгэн өгсөн болно.

3. Зүтгүүрийн дагалдан хүргэгч

(овог нэрийг заах)

Дагалдан хүргэгчид хүйтэн байдалд зүтгүүр (кран), моторт вагон (секц) тээвэрлэх заавар болон цахилгаанжуулсан төмөр замын хэсэгт ажиллах ажилтан аюулгүй ажиллагааны зааварчилгааны мэдлэгийг эзэмшсэн болно.

Замын аюулгүй ажиллагааны зааварлагч

Галт тэрэгний хөдөлгөөний _____ /..... /

дарга эсвэл түүний орлогч

Депогийн дарга _____ /..... /

Автотоормосын зааварлагч машинч

_____ /..... /

ЦТ МПС зааварлагч хүлээн авагч эсвэл

Зүтгүүрийн хүлээн авагч _____ /..... /

Зүтгүүрийн (кран), моторт вагоны дагалдан хүргэгч

_____ /..... /

_____ /..... /

_____ /..... /

_____ /..... /

_____ /..... /

_____ /..... /

Хос дугуйн хэмжилт

№	Секц	Хос дугуйн №	Хурц ирмэг	Дэл	Бандаажны зузаан
1					
2					
3					
4					
5					

МОП

Хос дугуй	Секц	1	2	3	4	5	6
Коллектор тал							
Араатай тал							

Авто угсраа, цас хамагч

Нэр	Дугаар	Өндөр, мм	Тайлбар
Урд авто угсраа			
Арын авто угсраа			
Цас хамагч			

Цехийн мастер

/

/

Хэмжигч техникч

/

/

---oOo---